



---

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН МОНГОЛ УЛСЫН  
2021 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛ БОЛОН ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ  
БАЙДЛЫН ЗЭРЭГ ХУУЛИУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН  
ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ, САНАЛ

---



Улаанбаатар хот

2021.07.01

**МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛ БОЛОН ТӨСВИЙН  
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗЭРЭГ ХУУЛИУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН  
ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ, САНАЛ**

*2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр*

УИХ-ын 2017 оны 83 дугаар тогтоолоор баталсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийн 3.1.1 дэх заалтад тусгагдсан бүрэн эрхийн хүрээнд тус Зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Монгол улсын 2021 оны төсвийн тодотголын тухай хуулийн төсөлтэй танилцсаны үндсэн дээр дор дурдсан дүгнэлт, саналыг гаргаж байна.

**Нэг. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх дүгнэлт, санал**

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах танилцуулгаас үзэхэд эдийн засаг 2021 онд өсөлттэй, тухайлбал Засгийн газрын тооцоолсноор 6.5 хувьд хүрэх төсөөлөлтэй байна. Энэхүү өсөлт бий болсноор **Төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх үндсэн** (Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл дахь 8.1.1.тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нь өмнөх жилтэй харьцуулахад “0”, эсхүл түүнээс бага, хасах хувьтай бол) **нөхцөл** арилсан гэж Засгийн газраас үзэж, мөн хуулийн 10.1.6.-д “төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгуулах саналыг хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасныг үндэслэн УИХ-ын 2020 оны 8 дугаар сарын 28-ны шийдвэрийг хүчингүй болгох санал ирүүлжээ.

Ийнхүү төсвийн тусгай шаардлагыг түдгэлзүүлэх тохиолдол арилсан бол төсвийн алдагдлыг ДНБ-ний 2 хувиас, Засгийн газрын өрийг 60 хувиас хэтрүүлэхгүй байх тусгай шаардлагыг мөрдөх учиртай билээ. Гэтэл Засгийн газар 2015 оноос эхлэн 2016, 2017, 2020 онд ДНБ-ний эзлэх төсвийн алдагдал, өрийн хэмжээг нэмэгдүүлсээр ирсэн нь Төсвийн тогтвортой байдлын тухай (2010) болон Төсвийн тухай (2012) хуулийн үндсэн зарчим, үзэл баримтлалыг зөрчиж байгаа юм.

Энэ төрлийн өөрчлөлтийг сонгуулийн өмнөх, эсвэл сонгуулийн жил, түүний дараах жилд хийх нь хэвшил болж байна. Эдгээр өөрчлөлтийн сөрөг үр дагавар нь дараах байдлаар илэрч байгаа юм. Тухайлбал, Монгол Улс дэлхийд хамгийн их өртэй орон болсон төдийгүй экспортын орлогынхоо 50 гаруй хувийг өрийн үйлчилгээнд зарцуулж байна. Түүнчлэн татварын орлогоор бүрдсэн мөнгөөр үр ашигтай хөрөнгө оруулалт хийж чадахгүйд хүрсний зэрэгцээ бизнес эрхлэгчдийн бүтээсэн нэмүү өртөг, төлсөн татварын дийлэнхийг тэтгэвэр, тэтгэмж халамж, давхардсан олон чиг үүрэг бүхий төсвийн байгууллага болон улсын үйлдвэрийн газрууд, тэдгээрийн барилга байгууламж, цахилгаан, дулааны зардалд зориулдаг болж Монгол Улс төсөв, санхүүгийн хүндрэлтэй байдалд ороод байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын энэ хүнд үед манай улсын эдийн засаг төлөвлөснөөс илүү өсөх хандлага ажиглагдаж, төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгох нөхцөл бүрдэж байгаа боловч төсвийн алдагдал, өрийн таазыг хэтрүүлж, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон бусад хуульд өөрчлөлт оруулдаг буруу арга барилыг дахин давтах хуулийн төслүүдийг Засгийн газраас өргөн барьсан байна.

Төсвийн алдагдлыг ДНБ-ний 2 хувиас, улсын өрийг 40 хувиас хэтрүүлэхгүй байх Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн заалтыг зөрчин УИХ-аас 2015 онд хууль гаргахдаа алдагдлыг 5 хувь, өрийг 58.3 хувь болгон нэмэгдүүлж, хуульд заасан 2 ба 40 хувийн харьцааг 2018 оноос мөрдүүлэхээр тогтоож байсан байна. УИХ-ын 2016 оны сонгуулийн дараа холбогдох хязгаарыг хэтрүүлсэн байсныг мөн цайруулж, алдагдлын хязгаарыг 10 гаруй хувиас дэс дараатайгаар багасган 2023 оноос хуулийн үндсэн шалгуур (2 хувь)-ыг мөрдөх, өрийн хязгаарыг 86 хувиас эхлэн бууруулж, 2021 онд 60 хувьтай байлгахад хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулсан байдаг.

Өнөөгийн Засгийн газар өмнөх алдааг дахин давтаж, 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн өргөн барьсан хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд төсвийн алдагдлын дээд хэмжээг 2020 онд 12.5 хувь болгож, үндсэн шалгуур 2 хувийг 2025 оноос мөрдөх, өрийн таазыг 88 хувиас бууруулж, 2024 онд 60 хувьд хүргэх заалтыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд оруулахаар нэмэлт, өөрчлөлтийн төслийг өргөн мэдүүлжээ. Энэ сөрөг үр дагавар бүхий хуулийн өөрчлөлтийг цаг алдахгүйгээр зогсоохгүй бол Монгол Улсын төсөв, төлбөрийн тэнцлийн алдагдал улам бүр нэмэгдсээр хяналтаас гарч болзошгүй байна.

Иймээс 2022 оноос эхлэн төсвийн алдагдлыг 2 хувьд хязгаарлан Засгийн газрын зардал, төсвийн байдал, өрийн бүтцэд шинжилгээ хийж, зардлыг багасгах, төсөвт өндөр ачаалал өгч буй бондуудын хүүг бууруулах, хямд эх үүсвэрээр солих боломжийг судлах хэрэгтэй тул энэ удаад УИХ-аас зөвхөн 2021 оны төсвийн тодотголыг авч үзэхийг санал болгож байна.

Төсвийн тодотголын гол зардал болсон хүүхдийн мөнгө олгох явдлыг Халамжийн тухай хуульд нийцүүлэн, өрхийн амьжиргааны түвшний судалгааны дүнд тулгуурлан амьжиргааны түвшин доогуур өрхүүдэд олгох нь зүйтэй. Ийм л хуулийн заалттай.

Төсвийн тусгай шаардлага болох төсвийн алдагдлыг ДНБ-ний 2 хувиас, Засгийн газрын өрийг 60 хувиас хэтрүүлэхгүй байх Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн заалтад өөрчлөлт оруулах эрх зүйн үндэс байхгүй бөгөөд зөвхөн түр хугацаагаар түдгэлзүүлэхийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд маш тодорхой заасан хэдий ч 2015 оноос эхлэн зөрчиж байгааг зогсоож, уг хуулийн үндсэн шаардлагыг 2022 оноос мөрдөх боломжтой гэж үзэж байна. Таваарын зарим бүтээгдэхүүн, тухайлбал, зэс, коксжих нүүрс, төмрийн үнэ, эрэлт ирээдүйд өндөр байх таамаглал байна. Зарим хөрөнгө оруулалтын арга хэмжээг төсвийн тусгай шаардлагад хамааруулахгүй байх эрх зүйн боломжийг ашиглах хэрэгтэй байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаар нь эрчим хүч, төмөр зам, уул уурхайн салбарын хуулийн этгээдэд Засгийн газар хувь нийлүүлсэн хөрөнгө оруулах нөхцөлийг бүрдүүлэх зориулалттай, хуулийн этгээдийн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсвэл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгаанд хамаарахгүй гэсэн заалтын дагуу Тавантолгойн цахилгаан станц, Газрын тосны үйлдвэр, Өмнийн говийн төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийг зохицуулах боломжтой болно.

Мөн хуулийн 10.1.5.-д “Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд<sup>1</sup> заасан аль нэг тохиолдол бий болсон бол төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр

---

<sup>1</sup> **Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл. Төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх тохиолдол**

8.1.Төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг дараах тохиолдолд түр хугацаагаар түдгэлзүүлж болно:

8.1.1.тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нь өмнөх жилтэй харьцуулахад “0”, эсхүл түүнээс бага, хасах хувьтай бол;

түдгэлзүүлэх тухай болон тусгай шаардлагад нийцүүлэх арга хэмжээний санал, шаардлагатай гэж үзвэл түүнтэй холбогдуулан тухайн жилийн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, тооцоо, үндэслэлийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан байдаг. Ийм тооцоо, судалгааны үндэслэл, хөтөлбөр одоогоор байхгүй байна. Нүүрс зэрэг бүтээгдэхүүний ачилт зогсоод буй өнөөгийн нөхцөл хэрхэн өөрчлөгдөх нь тодорхойгүй, мөн олон улсын зах зээлийн нөхцөл байдал нь Ковид-19 цар тахлын тархалтын цар хүрээ, зарим орнуудын бодлогоос хамааран муудаж болох эрсдэл байна. Ийм нөхцөлд дунд хугацааны шалгуур үзүүлэлтүүдийг өөрчлөх хууль батлах, таамаглаад байх боломж байхгүй. Харин ковидын үеийн буюу 2021 оны төсвийн тодотголд илүү ач холбогдол өгөхийг зүйтэй гэж үзэж байна.

### **Хоёр. Монгол Улсын 2021 оны төсвийн тодотголын төсөлд өгөх дүгнэлт, санал**

**Төсвийн орлогын тооцоолол:** Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөгөөр нүүрсний экспортын биет хэмжээ төлөвлөснөөс 13.3 сая тонноор багасаж байгаатай холбоотойгоор төсвийн орлого 368.0 орчим тэрбум төгрөгөөр буурахаар байна. Нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүдийн дизелийн түлшний хэрэглээ төлөвлөснөөс багасаж байгаа тул дизелийн түлшний онцгой албан татвар болон дизелийн түлшний албан татваруудыг мөн буурахаар тооцоолжээ. Тухайлбал, 2021 оны төсвийн тодотголын төсөл (Тооцооллын хавсралт хүснэгт №3)-өөс үзэхэд ААНОАТ 123.5 тэрбум төгрөгөөр өсөх бол онцгой албан татвар 60.0 тэрбум төгрөг, тусгай зориулалттай татвар 5.0 тэрбум төгрөг, НДШ-ийн орлого 100.0 тэрбум төгрөг, бусад төлбөр хураамж 91.0 тэрбум төгрөгөөр буурах тооцоог хийсэн байна.

Мөн 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажил олгогч болон даатгуулагчаас төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийг тус бүр 8.5 хувь, сайн дурын даатгуулагчийн тэтгэврийн даатгалд сард төлбөл зохих шимтгэлийн доод хэмжээг 11.5 хувь байхаар тогтоож өмнөх хэмжээнээс 1-2 нэгжээр бууруулжээ. Энэ өөрчлөлт нь Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуулиар баталсан НДШ-ийн орлогын төлөвлөгөөг 94.0 тэрбум төгрөгөөр тасалдуулж, энэ хэмжээгээр улсын төсвөөс тэтгэврийн даатгалын санд олгох татаас нэмэгдэх үр дагавартай байна.

Хэдийгээр татварын орлого буурах хандлагатай хэдий ч дэлхийн зах зээл дээрх эрдэс баялгийн үнийн өсөлттэй холбоотойгоор тогтворжуулалтын сангийн орлого 456.8 тэрбум төгрөг, татварын бус орлого 387.1 тэрбум төгрөгөөр тус тус өснө гэж өөдрөгөөр тооцоолсон байна. Цар тахлын нөлөөгөөр нүүрсний экспортын гол боомтуудаар нэвтрэх машины тоо буурч экспорт төлөвлөсөн хэмжээндээ хүрэхгүй байх магадлал өндөр үед төсвийн орлого, түүний дотор ААНОАТ-ын орлогыг нэмэгдүүлэх тодотгол хийхээр тооцсон нь эргэлзээ төрүүлж байна. Энэ нь төсвийн орлогод учирч болох бусад эрсдэлийн тооцоо, таамаглалыг нарийвчлан гаргах шаардлагатайг харуулж байгаа юм.

**Төсвийн зарлагад хийсэн тодотгол:** Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн батлагдсан төсвөөр 13,951.6 тэрбум төгрөг байсан бол тодотголын төсөлд 15,748.3 тэрбум төгрөг болж өсөхөөр тооцсон байна. Түүнчлэн урсгал зардлыг 2.0 их наяд

---

8.1.2.гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгахад төсвөөс нэмж шаардагдах санхүүжилтийн хэмжээ нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувь ба түүнээс дээш хэмжээнд хүрэхээр бол.

8.2.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-д заасан тусгай шаардлагыг энэ хуулийн 8.1-д зааснаас гадна Засгийн газрын гадаад өрийн багц дахь дийлэнх хувь хэмжээг эзэлж байгаа үндэсний мөнгөн тэмдэгттэй харьцах гадаад валютын Монголбанкнаас зарласан тухайн оны эцсийн албан ханш нь өмнөх оны мөн үеийн албан ханшаас 15 хувь ба түүнээс дээш хувиар өссөн тохиолдолд түр хугацаагаар түдгэлзүүлж болно.

төгрөгөөр өсгөхөөр тусгажээ. Төсвийн зарлагын өөрчлөлтийг зардлын үндсэн ангиллаар авч үзвэл:

- Цалингийн зардал 77 тэрбум төгрөгөөр өсөх
- Бараа, үйлчилгээний бусад зардал 236.4 тэрбум төгрөгөөр өсөх
- Татаас ба урсгал шилжүүлэг 1.87 их наяд төгрөгөөр нэмэгдэх
- Зээлийн үйлчилгээний төлбөр 172 тэрбум төгрөгөөр буурах
- Барилга байгууламжийн зардал 426.0 тэрбум төгрөгөөр буурах өөрчлөлт оржээ.

Төсвийн тодотголоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэл, хэрэгцээг оновчтой тодорхойлох үүднээс дараах зүйлсэд анхаарах нь чухал гэж үзэж байна. Тухайлбал,

- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2021 оныг дуустал 100.0 мянган төгрөгөөр үргэлжлүүлэн олгох арга хэмжээнд нийт 576.0 тэрбум төгрөг нэмж зарцуулна гэснийг нарийвчлан тооцоолж, өрхийн амьжиргааны түвшний судалгаанд тулгуурлан зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж олгосноор төлөвлөсөн зардлыг хэмнэж, үр ашигтай зарцуулах боломжтой гэж үзэж байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны гүйцэтгэл 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 356 төсөл, арга хэмжээнд 332.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 20.1%-ийн гүйцэтгэлтэй байгаа нь хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл хангалтгүй байгааг харуулж байна. Иймд барилга байгууламжийн зардлыг 426.0 тэрбум төгрөгөөр бууруулах тооцооллыг нягтлахын зэрэгцээ хөрөнгө оруулалтын ажил, төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд нарийвчилсан үнэлгээ, тооцоолол (*Хавсралт 1-д тусгагдсан мэдээллээс тодорхой үнэлгээ, дүгнэлт хийх боломжгүй байна*) хийж, тендер шалгаруулалт нь дуусаагүй, гэрээ байгуулаагүй, санхүүжилтийг нь хийж эхлээгүй төслүүдийг 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтаас дараагийн жилүүдэд шилжүүлж, санхүүжилтийг зогсоох нь зүйтэй. Учир нь цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны төсвийн жилийн сүүлийн хагаст төлөвлөгдсөн бүх хөрөнгө оруулалтын төсөл бүрэн хэрэгжих магадлал тун бага байна.

**Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд:** Монгол Улсын 2021 оны төсвийн тодотголд шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгахад нэгдсэн төсвийн нийт орлого 597.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 13,731.7 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн нийт зарлага 1,796.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 15,748.3 тэрбум төгрөг болох ба төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -3,691.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ийн -8.8 хувьтай тэнцэхээр байна.

**Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн 2021 оны үзүүлэлт**

*/тэрбум.төг/*

| Үзүүлэлтүүд                    | Батлагдсан      | Тодотгол        | Зөрүү           |
|--------------------------------|-----------------|-----------------|-----------------|
| <b>НИЙТ ОРЛОГО</b>             | <b>13,134.0</b> | <b>13,731.7</b> | <b>597.7</b>    |
| Тогтворжуулалтын сан           | 156.0           | 612.8           | 456.8           |
| Ирээдүйн өв сан                | 1,180.1         | 1,062.4         | -117.7          |
| <b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО</b>   | <b>11,797.8</b> | <b>12,056.4</b> | <b>258.6</b>    |
| <b>НИЙТ ЗАРЛАГА</b>            | <b>13,951.6</b> | <b>15,748.3</b> | <b>1,796.7</b>  |
| Урсгал зардал болон бусад      | 10,879.0        | 12,707.7        | 1,828.7         |
| Улсын төсвийн хөрөнгө оруулалт | 1,657.2         | 1,685.2         | 28.0            |
| Гадаад зээл, тусламж           | 1,415.4         | 1,355.4         | -60.0           |
| <b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ</b>   | <b>-2,153.7</b> | <b>-3,691.8</b> | <b>-1,538.1</b> |
| ДНБ-д эзлэх хувь               | -5.1%           | -8.8%           | -3.7%           |

**Төсвийн тусгай шаардлага:** Монгол Улсын 2021 оны төсвийн тодотголоор Ковид-19 цар тахлын эрсдлийг бууруулж, бэлэн байдлыг хангах, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах чиглэлд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээг үргэлжлүүлэхэд шаардагдах санхүүжилтийг нэмж тусгаснаар нэгдсэн төсвийн алдагдал төлөвлөснөөс ДНБ-ний 3.7 хувиар нэмэгдэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын хязгаарлалтуудыг дахин өөрчлөх шаардлагыг бий болгосон гэж Засгийн газар үзжээ.

Ингэснээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9 дэх хэсэгт заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-д эзлэх хувь хэмжээг 2021 онд 8.8 хувиас, 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсвэл ашигтай байхаар, мөн 19.3 дахь хэсэгт заасан өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2021 болон 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх хуулийн өөрчлөлтүүдийг тусгасан байна. Төсвийн тодотголыг хэлэлцэн батлахдаа ТХМ-ийн 2023-2024 оны үзүүлэлтүүдийг өөрчлөхгүйгээр зөвхөн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулаад, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үндсэн шаардлага, заалтыг өөрчлөхгүй байх нь зүйтэй гэж үзэж байна.

Макро эдийн засгийн болон төсвийн төсөөлөлд учирч болзошгүй эрсдэл нь эрдэс бүтээгдэхүүний экспорт төсөөлснөөс буурах; цаг агаарын хүчин зүйлсээс шалтгаалан хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурч, үнэ өсөх; импортын барааны саатал удаан үргэлжилж, дотоодын зах зээлд хомсдол үүсэх, нийлүүлэлтийн шалтгаантайгаар үнэ өсөх гэсэн 3 үндсэн шалтгааны улмаас эрсдэл учирч болзошгүй гэж үзсэн боловч эдгээр эрсдэлтэй холбоотой тодорхой тооцоолол, судалгаа хийгдээгүй байна.

Эдгээр дүгнэлтэд тулгуурлан 2021 оны төсвийн тодотголын төсөлтэй холбоотойгоор дараах саналыг гаргалаа. Үүнд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг богино хугацаанд (жил бүр), байнга өөрчлөхгүй байх эрх зүйн орчинг бүрдүүлж, анх тогтоосон тусгай шаардлагыг тасралтгүй хангаж ажиллах;
- Макро эдийн засгийн болон төсвийн төсөөлөлд учирч болзошгүй эрсдлийн тооцоолол, судалгаа хангалтгүй байгаа тул төсвийн тусгай шаардлагуудыг ерөнхийд нь мөрдөж, ковид-19 цар тахлын үед батлагдсан төсвийн хүрээнд багтаан зохицуулалт хийх замаар шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Төсвийн орлого, зарлага, тэнцэлд өөрчлөлт оруулах үндэслэл, тооцоолол тодорхой бус байгаа тул нэмэгдэж буй төсвийн зарлагыг хэмнэгдсэн зардлаар санхүүжүүлэх (сургууль, цэцэрлэгийн хоолны зардал гэх мэт), эсвэл хэрэгжиж эхлээгүй, нийгэм, эдийн засгийн ач холбогдол багатай хөрөнгө оруулалтын төслүүдийг зогсоох, зардлыг бууруулах арга хэмжээ авах, нөгөө талаас уул уурхайн бүсэд ковид-19-ийн тархалт ихсэх тохиолдолд зэс болон нүүрсний экспорт тасарч төсвийн орлого төсөвлөсөн хэмжээнд бүрэн төвлөрөхгүй байх магадлал өндөр байгаад анхаарал хандуулж төсвийн тодотголыг хийх;
- Улс төрийн болон сонгуультай холбоотой эрсдлийг татвар төлөгчид үүрч байгаа учир төрийн зүгээс өмнө гаргасан бодлогын алдаануудыг дэс дараатай засах замаар сөрөг үр дагаврыг багасгах бодлого баримтлах;
- Төсвийн нэгдмэл байдлыг эртнээс хангаж ажиллах (өмнө нь Монголбанкны төсөв, Хөгжлийн банкны төсөв, Сангийн яамны төсөв, Концессын төсөв гэж

байсан шиг Эрдэнэтийн төсөв, Эрдэнэс таван толгойн төсөвтэй болохоос сэргийлэх). 2021 оны сүүлийн хагаст үргэлжлүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийг төрийн өмчит үйлдвэрийн газруудаас гаргахыг хориглож, аж ахуйн нэгж болон өрхөд үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэгийн эх үүсвэр болон зардлыг нэгдсэн төсвийн орлого, зарлагадаа тусгаж батлах;

- Ингэснээр үндэсний томоохон үйлдвэрүүд үйлдвэрлэлээ өсгөх, техник, технологийн шинэчлэл, өргөтгөл хийх, мега төслүүдээ хэрэгжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, улс орны хувьд төсвийн орлогын найдвартай эх үүсвэртэй болох боломж бүрдэнэ гэж үзэж байна.

## ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

--oOo--